



ТӨВ АЙМГИЙН ХҮҮХЭД ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС 2013 оны Санхүүгийн Тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан Аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

Лавлах зүйлс байвал доорх хаягаар

холбоо барина уу:

Аймгийн Ерөнхий Аудитор

Л.Жаргалсайхан

Утас: 70272582

И-мэйл

Аудитын менежер

Т.Майцэцэг

Утас: 70273465

И-мэйл

Аудитор

О.Сосор

Утас: 70273204

И-мэйл

АГУУЛГА

ХУУДАС

• Танилцуулга	1-6
• Санхүүгийн дотоод хяналт	6
• Гол шийдлүүд	7
• Залруулаагүй алдаа	7
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	7
• Аудитын санал дүгнэлт	7

ТӨАГ-ын хаягийг оруулах

Төв аймаг Зуунмод сум 1-р баг Төрийн
байгууллагуудын ордон

Төв аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсийн

2013 оны Санхүүгийн Тайланд

ААГ аудит хийж дууссан тухай мэдэгдэл

Бид Аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсийн 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсийн төсвийн ерөнхийлөн захирагчид энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсийн Удирдлага тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирдлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

- Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг **тодруулбал:**

НББ-ийн үе шат бүрд дээд шатны түвшний удирдлага хүрдэг эсэх, нийтлэг чанартай зардал, төсвийн санхүүжилт, өөрийн орлого, цалингийн зардал, өглөг, авлага, балансын үзүүлэлтүүд, үндсэн хөрөнгө, бараа материал, бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

- Гол илрүүлсэн зүйлс аудитын үр дүнгээс гарсныг **тодруулбал:**

-Батлагдсан төлөвлөгөөний дүнг төсвийн хэлбэлзэл, төсвийн гүйцэтгэлийн тайлантай тохирч буй эсэхийг шалгахад Зарцуулах эрх батлагдсан төсвийн дүнтэй тохирч байна. Орлого санхүүжилтыг тайлан тэнцэлд бүрэн тусгасныг тулган шалгасан. 2013 оны урсгал санхүүжилт 237326.6 мянган төгрөгөөр батлагдсан. 2013 онд улсын төсвөөс 237326.6 мянган төгрөгийн урсгал санхүүжилт авч, нэмэлт санхүүжилт-2483.1 мянган төгрөг, нийт 239809.7 мянган төгрөгийг тайлан тэнцэлд бүрэн тусгасан байна.

Мөнгөн харилцахын журналаас sort filter – ийг ашиглан эх үүсвэрийг тайлан тэнцэлд тусгасаныг шалгахад мөнгөн гүйлгээний тайланд орлого, санхүүжилтийг бүрэн тусгасан байна.

- Үнэ төлбөргүй авсан 11521.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн орлогыг Сангийн сайдын 2013.12.02 ны өдрийн 269 тоот тушаалын дагуу Засгийн газрын оруулсан капитал дансны кт бичилтийг өөрчлөн орлого дансны кт болгон залруулах бичилт хийлгэсэн.

-

- ЕМ, Санхүүгийн албаны даргаас ААГ тайлбар мэдүүлэг хүлээж байгаа

-Илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар тайлбар ирүүлнэ үү

Санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илэрээгүй тул Зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар Ерөнхий аудиторт санал оруулсан байгаа.

Аймгийн Ерөнхий Аудитор 2014 оны 03-р сарын 05-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад Ахлах нягтлан бодогч Б.Нямхүү олон бусад бидэнтэй хамтран ажилласан ажиллагсдын байнгын дэмжлэг туслалцаа бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

Аудитор

О.Сосор

Төв аймгийн Аудитын Газар

2014.03.04

Танилцуулга

1. Бид Аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсийн 2013 оны 12 дугаар сарын 31-р тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсийн даргад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсийн тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.
2. Бидний 2013 онд тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:
 - Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
 - Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.

3. ААГ санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсийн хяналтыг ААГ-ын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм. Аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсийн даргад тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.

4. Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсийн удирдлагын анхаарлыг хандуулж байна.

1 .Орлого,санхүүжилтийн талаар

Орлого санхүүжилтыг тайлан тэнцэлд бүрэн тусгасныг тулган шалгасан. 2013 онд батлагдсан төлөвлөгөөний дүнг төсвийн хэлбэлзэл, төсвийн гүйцэтгэлийн тайлантай тохирч буй эсэхийг шалгахад зарцуулах эрх батлагдсан төсвийн дүнтэй тохирч байна. Орлого санхүүжилтыг тайлан тэнцэлд бүрэн тусгасныг тулган шалгасан. 2013 оны урсгал санхүүжилт 237326.6 мянган төгрөгөөр батлагдсан. 2013 онд улсын төсвөөс 237326.6 мянган төгрөгийн урсгал санхүүжилт авч, нэмэлт санхүүжилт-2483.1 мянган төгрөг, нийт 239809.7 мянган төгрөгийг тайлан тэнцэлд бүрэн тусгасан байна.

Мөнгөн харилцахын журналаас sort filter –ийг ашиглан эх үүсвэрийг тайлан тэнцэлд тусгасаныг шалгахад мөнгөн гүйлгээний тайланд орлого,санхүүжилтийг бүрэн тусгасан байна.

2.Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 1705082.3 мянган төгрөг, тайлант онд үндсэн хөрөнгө нь 11521.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, данснаас хасагдсан хөрөнгө байхгүй, оны эцэст 1716603.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын яамнаас 10000.0 мянган төгрөг,НҮБ-ын хүүхдийн

сангаас 1521.0 мянган төгрөгийн хөрөгө ирснийг хүлээн авсан акт шийдвэрийг үндэслэн холбогдох дансад орлогодсон байна.

Үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтсийн даргын 2013.11.18 ны өдрийн А/28 тоот тушаалаар томилж тооллогын комиссууд тооллогыг хийсэн байна.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг Засгийн газрын 2005 оны 233-р тогтоолын дагуу шулуун шугамын аргаар тооцсон байна.

3.Бараа материал

Бараа материалын орлогын гүйлгээг харилцах данснаас шилжүүлсэн тохиолдолд авлага өглөгийн дансаар дамжуулан бүртгэсэн байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 5366.3 мянган төгрөг, орлого 12527.0 мянган төгрөг, зарлага 9209.7 мянган төгрөг гарч 8683.6мянган төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй байна.

Бараа материал дансанд хөтлөгдөх анхан шатны баримтыг хэсэгчлэн шалгахад тайлан гаргалт, баримт бүрдүүлэлт орлого, зарлагын баримт, шаардах хуудасанд зөвшөөрсөн,олгосон хүний гарын үсэг бүрэн зурагдсан баримтын бүрдэл сайн, нярав нэр төрлийн тайланг сар бүр гаргасан байна.

4.Цалингийн талаар

Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтсийн 2013.01.18 ны өдрийн А/01 тоот тушаалаар ажилтан албан хаагчдын цалинг шинэчлэн тогтоосон. Батлагдсан төсвийн 32.7 хувь буюу 77729.7 мянган төгрөгийг цалин, НДШ-ийн зардал эзлэж байна. Цалин хөлс тогтоолтын байдлыг шалгаж үзэхэд Засгийн газрын 2012 оны 78 тоот тогтоолын дагуу цалингийн шатлал,зэрэглэлийг тогтоож цалинг бодож олгосон байсан.Цалингийн сан 71801.4 мянган төгрөгөөр батлагдсан.Гүйцэтгэлээр 70090.3 мянган төгрөг зарцуулж 1711.0 мянган төгрөгийг зарцуулаагүй үлдэгдлийг төсөвт татан төвлөрүүлсэн.

Цалингийн баримтыг шалгахад цалингийн хүснэгтэнд ажиллагсадаар гарын үсэг бүрэн зуруулсан. Цалин хөлсийг санхүүгийн программаар бодож хэвшсэн байна.

5.Бараа үйлчилгээний зардал

Бараа үйлчилгээний зардлуудыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудаас ирүүлсэн нэхэмжлэхийн дагуу шилжүүлсэн байна. Бараа үйлчилгээний зардлуудыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудаас ирүүлсэн нэхэмжлэхийн дагуу шилжүүлсэн байна.

Гэрэл цахилгааны зардлаас 550.0 мянган төгрөгийг СТСХэлтэст 2013.05.10 ны 07/70 тоотоор хүсэлт гарган төлбөр хураамж, бусад зардалд гүйлгэн зарцуулсан байна. 2013.11.13ны өдрийн 07/146тоотоор хүсэлт гарган ичээл үйлдвэрлэлээс,нэг удаагийн тэтгэмж урамшлалд 83.5 мянган төгрөгийг, Засаг даргын 2013.12.23 ны өдрийн А/677 тоот захирамжаар гэрэл цахилгааны зардлаас, төлбөр хураамж бусад зардалд 1111.0 мянган төгрөгийг шилжүүлсэн зарцуулсан байна.Зардлын гүйцэтгэлийг үр дүнгийн тайланд бодит байдлаар тайлагнасан байна.

6.Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн тайлан гаргалт анхан шатны баримтын бүрдлийг хэсэгчлэн шалгахад мөнгөн хөрөнгөнд хөтлөгдөх анхан шатны баримтыг зохих журмын дагуу бүрдүүлсэн байна.Төрийн сангаас гүйлгээ хийсэн баримт бүрт төрийн

сангийн тэмдэг дарж баталгаажуулсан байна. Цалин, НДШимтгэл, албан томилолтын зардал 2092.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэнийг буцаан төвлөрүүлсэн. Харилцахаас кассад 1684.3 мянган төгрөг авч зарцуулсан. Төсвийн болон нэмэлт санхүүжилтын дансдын үлдэгдлийн баталгааг гаргаж төрийн сангаар баталгаажуулсан байсан.

7. Авлага, өглөгийн талаар

Авлага өглөгийн журналыг ерөнхий дэвтрийн данстай тулган баталгаажуулсан.

Ажил гүйлгээг тухай бүрд нь өглөг, авлаг үүсгэн бүртгэсэн.

Төв Чандмань ДЭХГ-т оны эхэнд 61162.1 мянган төгрөгийн өглөгтэй байсан. Тайлант онд халаалт болон цэвэр, бохир усны үнэнд нэхэмжлэхээр 138648.3 мянган төгрөгийн шилжүүлсэн байна. Төв чандмань ДЭХГ-аас ирүүлсэн тулган баталгаажуулалтаар 41765.3 мянган төгрөгийн өглөгтэй гэж ирүүлсэн. халаалтын өр 41765.3 мянган төгрөгийг өглөгөөр тусгасан байна.

Цахилгааны үнэнд 2056.0 мянган төгрөг нэхэмжлэхээр төлсөн. ХҮТ-өөс ирүүлсэн өр, авлагын тооцоогоор 2056.0 мянган төгрөг байгаа нь төлсөн мөнгөий дүн тохирч байна.

Татварын хэлтэст 8.0 мянган төгрөгийн өглөгтэй гарсан. Ажил гүйлгээг тухай бүрд нь өглөг, авлаг үүсгэн бүртгэсэн. Харилцагч НДХэлтэс, Холбооны газар, ШҮҮГазар, Хот тохижуулах газар, Төв Цогт-өлзитий ХХК, Мөнхбүрд ХХК, Мандухай ХХК, Магнайтрейд, Ган судар ХХК, БТМ ХХК, Нарны титэм ХХК, Төв агро ХХК зэрэг байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдсэн байна.

8. Санхүүгийн дотоод хяналтын талаар

МУ-ын ЗГазрын 2011.11.09 –ний өдрийн 311-р тогтоолоор аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам батлагдсан байна. Энэхүү журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам” –ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө гэж заасны дагуу байгууллагад дотоод хяналт шалгалтыг хэрхэн хийж байгаа талаар шалгахад байгууллагын дотоод хяналт шалгалт хийх комисс нь 2013 онд хийх ажлын төлөвлөгөө гаргаж батлуулан хяналт шалгалтыг хийж ажилласан байна.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

5. Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

6. Эдгээр асуудлуудыг ААГ болон Аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсийн удирдлага авч үзэж хангалттайгаар шийдсэн. Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрөхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

7. Аудитын стандарт нь ААГ-г аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Аудитаар залруулаагүй алдаа гараагүй болно.

Тайлбар мэдүүлгийн захидал

8. Аудитын үйл явцад ААГ хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн ажилтанаас эдгээр баталгааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлт

2013 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараахь зөвлөмжүүд өгөгдсөн.

- Батлагдсан орон тоо,цалингийн санд багтаан үйл ажиллагаа явуулах.
- Дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах
- Зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулахгүй байх
- Өглөг,авлагыг тайланд тусгаж ,тооцоо нийлсэн акт үйлдэж байх гэсэн зөвлөмжүүд өгөгдсөн байна.

Дээрхи зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Аудитын санал дүгнэлт

9. Аймгийн Аудитын газраас тус тайланд **зөрчилгүй** санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

Аймгийн Аудитын газар

2014.03.05